



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/116

Сүхбаатар сум

Хилийн дэглэм зөрчсөн айл өрх, иргэдийг  
хилийн зурвасаас албадан гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 30 дугаар зүйлийн 30.1.6, 30.1.17, Монгол Улсын Хилийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.2, 53 дугаар зүйлийн 53.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Хилийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2 дахь заалт буюу "Улсын хилийн болон хил орчмын дэглэмийн шаардлагыг биелүүлэх" үүргээ удаа дараа зөрчсөн зөрчил гаргаж байгаа тул Хүдэр сумын Тарвагатай 1 дүгээр багийн иргэн О.Батхүү, Ц.Уламбаяр нарын иргэдийг гэр бүлийн хамт хилийн зурвасаас албадан гаргасугай.

2. Хилийн дэглэм зөрчсөн иргэдийг хилийн зурвасаас албадан гаргах арга хэмжээг хууль тогтосмжийн хүрээнд хамтран хэрэгжүүлэхийг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/, Тагнуулын газрын дарга, дэд хурандаа /Б.Амаржаргал/, Хүдэр сумын Засаг дарга /Д.Пүрэвдорж/, Хилийн 0243 дугаар ангийн захирагч, хурандаа /Б.Гантөмөр/ нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, цаашид энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллахыг аймаг, сумын Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн Нарийн бичгийн дарга нарт болон Хилийн 0243 дугаар ангийн захирагч, хурандаа /Б.Гантөмөр/-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ